

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/3

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.III	2023.III	2024.II	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 4-р улирал	их наяд ₮, оны үнээр	68.8	52.8	68.8	-	-	-	7.0% ▲
Инфляц	хувь	7.0	12.2	7.0	0.9% ▲	-	2.5% ▲	-5.2 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	3.9% 2023 оны У4	5.3% 2022 оны У4	3.9% 2023 оны У4	-	-1.3% ▼ нэгж хувиар	-	-1.4% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1626	656	1342	284 ▲	-	-	970 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3376.22	3524.98	3391.80	-15.58 ▼	-	-	-148.76 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	1244.6	1824.4	1050.5	-	-	-	-580 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	17.7	14.1	10.6	-	-	-	3.6 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	367.4	362.9	253.6	-	-	-	1% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	12%	13%	13%	-1%	-	0%	0%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	5.25	3.44	4.97	5.62% ▲	-	-	52.68% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	7.06%	9.58%	7.29%	-0.22 нэгж хувиар ▼	-	-	-2.52 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Эрдэнэс Тавантолгой компанийн ногдол ашиг тараав.	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ТУЗ 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 266 төгрөг буюу 1,072 хувьцаа эзэмшигч иргэн бүрд 285,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилав.
Малчдад зориулж 5 их наядын хөтөлбөр хэрэгжүүлнэ.	"Малчин хоршоо, бүлгийн гишүүн болно. Ингэснээр малчин хамтын хариуцлагын урт хугацааны хөнгөлөлттэй зээл авах боломжийг нээж өгнө. Тэгэхийн тулд Засгийн газар 5 их наяд төгрөгийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Монголбанк бодлогын хүүгээ бууруулав.	3/15/2024	Жилийн инфляц 2024 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувь, Улаанбаатар хотод 7.2 хувьд хүрч буурлаа. Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлого, худалдааны түнш орнуудын буурч буй инфляц, чангарч буй төгрөгийн гадаад валюттай харьцах ханш зэрэг нь нийт инфляцын бууралтад гол нөлөө үзүүлэв. Цаашид инфляц алгуур буурч, төв банкны зорилтын дээд интервалын орчимд байх төлөвтэй байна.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График

Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 3 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.0 хувь, өмнөх оны эцсээс 2.5 хувь, өмнөх сараас 0.9 хувиар өссөн байна. 2024 оны 3 дугаар сард Хангайн бүсэд барааны бүлгийн үнэ 8.2 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 7.6 хувь, Төвийн бүсэд хүнсний бүлгийн үнэ 11.4 хувь, Улаанбаатар хотод хүнсний бус бүлгийн үнэ 6.1 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 3 дүгээр сард 3376.22 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 148.76 төгрөгөөр, өмнөх сараас 15.58 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 5.62%, өнгөрсөн жилийн мөн үеэс 52.68%-р тус тус өсөж, 5625 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 7.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 (51.3%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 7.3 их наяд төгрөгт хүрч, 2.5 (52.7%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний 3 сард 5.7 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 3 сард нийт 128 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 3.7 тэрбум ам.доллар, импорт 2.4 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 1.2 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Экспорт 2024 оны эхний 3 сард өмнөх оны мөн үеэс 107.5 сая ам.доллороор буурахад цайрын хүдэр, баяжмал 74.4 сая ам.доллороор, нүүрс 38.7 сая ам.доллороор, адууны мах 32.6 сая ам.доллороор, лаазалсан махан бүтээгдэхүүн 31.6 сая ам.доллороор тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 3-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 3-р сар 2024 он, Монголбанк](#)
3. www.1212.mn, www.mongolbank.mn